



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/А

Чингис хот

2020 оны цэргийн бүртгэл явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 30 дугаар зүйлийн 30.1.6, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.17, Батлан хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.4, Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2020 оны цэргийн бүртгэлийг 01 дугаар сарын 15-аас 25-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулж явуулсугай.

2. Цэргийн бүртгэлийг зохион байгуулах комиссыг доор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга	Ж.Ганбаатар	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
Гишүүдэд	Н.Хүрэлээ	Цэргийн штабын дарга, Хурандаа
	Н.Чанцал	Онцгой байдлын газрын дарга, Дэд хурандаа
	Г.Сэдэдмаа	Статистикийн хэлстийн даргыг түр орлон гүйцэтгэгч
	Б.Төрхүү	Улсын бүртгэлийн хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Л.Цэнддорж	Цэргийн штабын тоо бүртгэлийн офицер, Хошууч

3. Цэргийн бүртгэлийг зохион байгуулах сумын комиссыг холбогдох албан тушаалтнуудыг оролцуулан 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, Бэлтгэл офицер, 1, 2 дугаар зэргийн бэлтгэл үүрэгтэн, цэргийн өмнөх насны идэрчүүд, тусгай мэргэжлийн эмэгтэйчүүд, тайван цагт цэргийн жинхэнэ албанд тэнцэхгүй бүртгэлд орсон иргэдийг бүрэн хамруулж, 2019 оны жилийн эцсийн хүн амын тоотой тулган, тоо бүртгэлийн материал, мэдээ судалгааг маягтын дагуу гаргаж, тогтоосон хугацаанд сумын Засаг даргын Тамгын газрын дарга /тосгоны Захирагчийн ажлын албаны дарга/-аар хүргүүлэхийг сумын Засаг дарга, тосгоны Захирагч нарт үүрэг болгосугай.

4. Цэргийн бүртгэлийн явцын байдалд хяналт шалгалт хийж, заавар зөвлөмж өгөх, илэрсэн зөрчлийг арилгах арга хэмжээ авах, цэргийн бүртгэлийн материалыг тогтоосон

231010029

2.

хугацаанд сумдаас хүлээн авч зааврын дагуу нэгтгэх, нэгдсэн дүн мэдээг 2020 оны 2 дугаар сарын 20-ны дотор Зэвсэгт хүчний Жанжин штабт хүргүүлэхийг комиссын дарга /Ж.Ганбаатар/-д үүрэг болгосугай.

5. Цэргийн бүртгэлийн явцтай танилцах шалган зааварлах хуваарийг 1 дүгээр, сумд цэргийн бүртгэлийн материал тушаах хуваарийг 2 дугаар, шаардагдах төсвийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

6. Цэргийн бүртгэлийг зохион байгуулахад шаардагдах 1500550 /нэг сая таван зуун мянга таван зуун тавин/ төгрөгийг Засаг даргын нөөц сангийн Цугларалт, бэлтгэл сургууль, дайчилгаа, түр цэргийн зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Аймгийн Засаг даргын 2019 оны  
01 дугаар сарын 06 өдрийн 1/1  
дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

2020 ОНЫ ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙН ЯВЦТАЙ  
ТАНИЛЦАЖ, ШАЛГАН ЗААВАРЛАХ ХУВААРЬ

д/д	Сумдын нэр	Шалган зааварлах хүний нэр	Он. сар. өдөр
1.	Жаргалтхаан	Хошууч Л.Цэнддорж	2020.01.15
2.	Цэнхэрмандал		2020.01.15
3.	Өмнөдэлгэр		2020.01.16
4.	Баян-Адарга		2020.01.16
5.	Батноров	Хурандаа Н.Хүрэлээ	2020.01.22
6.	Норовлин		2020.01.22
7.	Дадал		2020.01.23
8.	Баян-Овоо		2020.01.24
9.	Хэрлэн 1-р баг	Хурандаа Н.Хүрэлээ Хошууч Л.Цэнддорж	2020.01.15-2020.01.25
10.	Хэрлэн 2-р баг		
11.	Хэрлэн 3-р баг		
12.	Хэрлэн 5-р баг		
13.	Хэрлэн 6-р баг		
14.	Хэрлэн 8-р баг		

Аймгийн Засаг даргын 2019 оны  
 01 дугаар сарын 06 өдрийн А/А  
 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

2020 ОНЫ ЦЭРГИЙН ШИНЭЧИЛСЭН ТОО БҮРТГЭЛИЙН  
 МАТЕРИАЛ ТУШААХ ХУВААРЬ

д/д	Сумдын нэр	Он, сар, өдөр	Цаг	Ирсэн цаг
1	Хэрлэн 1-р баг	2020.01.25	08.00	
2	Хэрлэн 2-р баг		10.00	
3	Хэрлэн 3-р баг		14.00	
4	Хэрлэн 4-р баг		16.00	
5	Хэрлэн 5-р баг	2020.01.26	08.00	
6	Хэрлэн 6-р баг		10.00	
7	Хэрлэн 8-р баг		14.00	
8	Өлзийт	2020.01.27	15.00	
9	Цэнхэрмандал		09.00	
10	Жаргалтхаан		11.00	
11	Мөрөн		14.00	
12	Галшар	2020.01.28	15.00	
13	Өмнөдэлгэр		09.00	
14	Гурванбаян		11.00	
15	Батширээт		14.00	
16	Баян-Адрага	2020.01.29	15.00	
17	Дадал		09.00	
18	Норовлин		11.00	
19	Баян-Овоо		14.00	
20	Бор-Өндөр	2020.01.30	15.00	
21	Батноров		09.00	
22	Бэрх		11.00	
23	Дархан		14.00	
24	Баянмөнх	2020.01.31	15.00	
25	Дэлгэрхаан		09.00	
26	ХБУлаан		11.00	
27	Баянхутаг		14.00	
28	Биндэр		15.00	

Аймгийн Засаг даргын 2019 оны  
01 дугаар сарын 06 өдрийн 01/1  
дугаар захирамжийн гуравдугаар хавсралт

2020 ОНЫ ЦЭРГИЙН БҮРТГЭЛИЙН ТӨСӨВ

д/д	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Хянасан
1	Цэнхэрмандал, Жаргалтхаан Өмнөдэлгэр, Баян-Адарга сумын цэргийн бүртгэлийн явцтай танилцаж, шалган зааварлах	80 л Аи-92	1910	152.800	
2	Батноров, Норовлин, Дадал, Баян-Овоо сумын цэргийн бүртгэлийн явцтай танилцаж, шалган зааварлах	95 л Дизель түлш	2490	236.550	
3	Томилолтын зардал	4 хүн*2хоног	26500	212.000	
4	Цэргийн бүртгэлийн маягт хэвлүүлэх	1000	400	400.000	
5	Батлан хамгаалах хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн сурталчилгааны материал хэвлүүлэх	1000	450	450.000	
6	Бичгийн цаас	1	10000	10.000	
7	Хавтасны материал	28	1400	39.200	
	<b>Нийт</b>			<b>1.500.550</b>	